

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО,
ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар
2021 оны 8 дугаар сар

АГУУЛГА

Агуулга.....	2
Товчилсон үгийн жагсаалт.....	2
Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
Аудитын зорилт.....	3
Аудитын хамрах хүрээ.....	3
Үндсэн мэдээлэл.....	3-4
Эрсдэлийн үнэлгээ.....	4
Аудитын арга зүй.....	4
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	4
Аудит хийх хугацаа	5
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	5
Аудитын хөтөлбөр.....	5
Аудитад шаардагдах нөөц.....	6

Хавсралт №1 Аудитын эрсдэлийн үнэлгээ

Хавсралт №2 Асуудлын шинжилгээ

Хавсралт №3 Аудитын загварын матриц

Хавсралт №4 Аудитын хөтөлбөр

Хавсралт №5 Аудитын багийн ажлын хуваарь

Хавсралт №6 Материаллаг байдлын тооцоолол

Хавсралт №7 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

Товчилсон үгийн жагсаалт:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын сэдэв:

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт

2. Аудитын код: АГГ-2021/15-ШТА-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийнэ.

4. Аудитын зорилго:

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан Улсын Их хурлын болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийнэ. Үүнд:

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх;
- Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Дотоод Аудиторуудын Олон Улсын Институтээс 2017 онд бүрэн хэмжээний өөрчлөлт оруулсан Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандарт (ДАМПОУС)-д “Дотоод аудит”-ыг “Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл явцыг үнэлэн, хараат бус үнэлгээ өгөх зорилгоор зохих нотолгоонд үндэслэн хийж байгаа шалгалт” гэж тодорхойлжээ.

Төсвийн тухай хуульд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл

ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна гэж заасан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д төрийн байгууллагуудын дотоод аудитын албаны үйл ажиллагаанд бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн засаг захирагааны дотоод аудитын алба, тэдгээрийн харьяа байгууллагын дотоод аудитын албадын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хамаарахаар тусгагдсан байна.

Дотоод аудитын дүрэм нь дотоод аудитын нэгжийн зорилго, эрх ба үүргийг тодорхойлсон бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт”, 2019 оны 29 дүгээр тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”, 2019 оны 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, 2019 оны 274 дүгээр тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”, “Чанарын үнэлгээний аргачлал”-ыг тус тус баталсан байна.

Дээрх эрх зүйн баримт бичгүүдэд дотоод аудитын төлөвлөлт, дотоод аудитыг хэрхэн гүйцэтгэх, тайлгаха, зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянах үе шат бүрийг тусгаж өгснөөс гадна нийцэл, гүйцэтгэл, санхүүгийн аудит болон мэдээллийн технологийн засаглал, түүний эрсдэл, хяналтыг үнэлэх талаар арга зүй, аудитын явцад ашиглах ажлын баримтын загваруудыг тус тус багтаасан бөгөөд ТЕЗ-ийн дотоод аудитын үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих, төсвийн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах талаар тодорхой заасан байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДҮНД” гэж үнэлсэн. (Эрсдэлийн үнэлгээг хавсралт 1-д үзүүлэв)

8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт, түүний тайлгагналын үйл ажиллагаа, хяналт шинжилгээний үнэлгээ зэрэг бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага, дүн шинжилгээ хийх, аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж

боловсруулна. Аудит хийх “Асуудлын шинжилгээ”-г хавсралт-2-т, “Аудитын арга зүй”-г хавсралт 3-т тус тус үзүүлэв.

9.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль;
- УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”;
- Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт”;
- Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”;
- Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

10.Аудит хийх хугацаа:

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн, аудитын төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудитораар 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор батлуулна.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гүйцэтгэх бөгөөд аудиторууд талбарын ажлын явцад аудитын дэд тайланг зэрэгцүүлэн бичиж, үе шатны чанарын хяналтыг хийлгэнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд энэхүү төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, тайланг баталгаажуулж, холбогдох судалгаа, зөрчлийн жагсаалтын хамт Үндэсний аудитын газарт 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд орон нутгийн онцлогт тохируулж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг дахин баталж болно.

Аудитын нэгдсэн тайланг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэн, Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж батлуулан, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яам болон Төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлнэ.

11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын Гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Болормаа, аудитор Ш.Наранбаатар, Ж.Оюунтуяа, Ч.Баярмаа нар гүйцэтгэнэ.

12. Аудитын хөтөлбөр:

Асуудлын шинжилгээнд тусгагдсан асуудлаар багийн гишүүд аудитыг гүйцэтгэх бөгөөд аудитын хөтөлбөрийг хавсралт 4-т үзүүлэв.

13. Аудитад шаардагдах нөөц:

Б. ТӨЛӨВЛӨГӨӨГХ ХЭРЭГСЭЛ: Зөөврийн компьютер, диктафон, зургийн аппарат, бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг хянаж, зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

Хянасан:

АУДИТОРЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХБОЛД

АУДИТОРЫН МЕНЕЖЕР

Б.ДОЛГОРСҮРЭН

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

Б.БОЛОРМАА

АУДИТОР

Ш.НАРАНБААТАР

Ж.ОЮУНТУЯА

Ч.БАЯРМАА

2021 оны 08 дугаар сарын 27-ны өдөр

¹ Аудиторуудын цалинг үндсэн цалингаар тооцоолон 1 өдрийн цалинг дунджаар тооцоолов

² Газрын захирал, аудитын менежерийн цалина үндсэн цалингаар тооцоолон 1 өдрийн цалинг дунджаар тооцоолов